

“ЦЕМЕНТ ШОХОЙ” ТӨХК



СЭЛЭНГЭ АЙМАГ САЙХАН СУМ ХӨТӨЛИЙН “ЦЕМЕНТ ШОХОЙ” ТӨХК-ИЙН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

**/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР-12219А, 15249А/
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР-2641984/**

Хянасан:

БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газрын
мэргэжилтэн

.....П.Шинэцэцэг

Биелэлтийг тайлагнасан:

“Цемент Шохой” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал.....Л.Наранбаатар

“Цемент Шохой” ТӨХК-ийн

ХАБЭАБОХэлтсийн даргаД.Баттулга

ХАБЭАБОХэлтсийн мэргэжилтэн.....Б.Дөлгөөн

ХАБЭАБОХэлтсийн мэргэжилтэн.....З.Болортуяа

Сэлэнгэ аймаг, Сайхан сум, Хөтөл 2022 он

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	3
1.1 Хөтөлийн Цемент Шохойн үйлдвэр	3
1.2 Шохойн чулууны орд	5
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	8
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	9
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	12
5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	16
5.1 ТЕХНОЛОГИЙН ХАЯГДАЛ ХУРИМТЛАГДСАН ТАЛБАЙ ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ:	17
6. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ	18
7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	19
8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	20
9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	20
10. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	22
11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	24
12. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ	26
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	27
14. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГИЙН ХҮРЭЭНД	28
15. АЙМАГ, СУМЫН ОРОН НУТГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ШААРДЛАГААР ХИЙСЭН АЖИЛ БОЛОН НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	29
ДҮГНЭЛТ	30

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хөтөлийн “Цемент Шохой” ТӨХК-ийн Байгаль орчныг хамгаалах бодлогын гол зорилго нь “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчныг хамгаалах тухай” болон бусад холбогдох хууль, дүрэм, журам, компанийн үндсэн бодлогын дагуу явуулахад оршино.

1.1 Хөтөлийн Цемент Шохойн үйлдвэр

Хөтөлийн “Цемент Шохой” үйлдвэр нь 1983 оны 10 сараас эхлэн 39 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Тус үйлдвэрийн газар нь Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт, Дархан хотоос урагш 60 км, Эрдэнэтээс 120 км, Улаанбаатар хотоос 260 км-т байрлана.



Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт Хөтөлийн шохойн чулууны ордыг түшиглүүлэн Цемент Шохойн үйлдвэр барих тухай Улсын Төлөвлөгөөний комиссын шийдвэр 1978 онд гарч тухайн үеийн ЗХУ-ын Новосибирск хотын “СИБНИЙПРОЕКТ ЦЕМЕНТ” эрдэм шинжилгээний хүрээлэнд зураг төсвийг зохиож барилгын ажлыг 1981 оноос эхлүүлсэн түүхтэй.

Шохойн үйлдвэр нь жилд 65.0 мян.тн шохой үйлдвэрлэх хүчин чадалтайгаар 1984 оноос, Цементийн үйлдвэр жилд 500.0мян.тн цемент үйлдвэрлэх хүчин чадалтайгаар 1985 оноос эхлэн одоог хүртэл үйлдвэрлэлээ тасралтгүй явуулж байгаа ба 2014 оноос хоногт 2500 тн чулуунцар үйлдвэрлэх хүчин чадалтай цементийн хуурай аргын үйлдвэр ашиглалтанд орсон бөгөөд хуурай технологийн үйлдвэр нэмэгдсэний дараах үйлдвэрийн нийт хүчин чадал нь одоогийн суурилуулсан хүчин чадалд 1,000,000 тн/жил байна.

Тус үйлдвэрт нийтдээ 768 орчим ажилчид ажиллаж байгаа ба Чулуунцарын үйлдвэр, Цементийн үйлдвэр, Шохойн үйлдвэр, Геологи уул уурхай, Дулааны станц гэсэн үндсэн цех, Механик, Цахилгаан, Нарийн хэмжүүр, Компрессор, Лаборатори, Тээвэр логистикийн алба, Савлах, Борлуулах зэрэг туслах цех тасаг, мэргэжлийн албад, захиргаа гэсэн үндсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

“Цемент Шохой” ТӨХК

Эрчим хүчний хангамж: Цахилгаан эрчим хүчийг Дархан хотоос 110 кВТ-ын шугамаар Хөтөлийн ГПП 110/35/6 кВТ-ын дэд станцид хүлээн авч Шохойн үйлдвэрийн “ТП” 2-р станциар дамжуулан хуваарилана.

Цэвэр усны хангамж: Ус хангамжийн эх үүсвэр нь үйлдвэрлэлийн талбайгаас 20 км-т, Орхон сумаас 2,5 км зайд Орхон голын хөндийд оршино. Ус хангамжид 50-57м гүн бүхий 50-83л/сек ундаргатай 3 өрмийн цооногоос авч байна. Усны чанар, түүнийг цэвэршүүлэлтийг мөрдөгдөж буй стандартын дагуу гүйцэтгэж байна.

Ус хангамжийн сүлжээнд:

- Ус хураагуурын цооногууд
- Магистрал шугам (2 дахь өргөлтөөс үйлдвэрийн талбай хүртэл)
- 3 ба 4 өргөлтийн насосын станцууд
- Усан сан

Тус үйлдвэрт ахуйн ус хангамжид зориулсан нэгдсэн систем байгуулагдаж, бохир ус цэвэршүүлэх байгууламжид үйлдвэрийн хаягдал ус болон ахуйн ус түгээгүүр хамаарагддаг болно.

Үйлдвэрийн талбайн гаднах сүлжээ ба цэвэршүүлэлтийн байгууламжид:

- Даралтат өөрөө урсах коллектор (Үйлдвэрийн талбайгаас цэвэршүүлэх байгууламж хүртэл)
- Цэвэршүүлэлтийн насосын станц
- Цэвэршүүлэх сүлжээний байгууламжийн цогцолбор
- Цэвэршүүлсэн усны даралтат өөрөө урсах коллектор орно.

Төслөөр хэрэгжүүлсэн цэвэршүүлэх байгууламж бүхэлд нь цэвэршүүлэхээр тооцоноор хоногт 2133 м³ ба цэвэршүүлэлтийн ууршуулалтын талбайгаас 1 км зайд задгай зайлуулна.

Үйлдвэрийн бохир усны систем: Үйлдвэрлэлийн технологиос гарах пульпыг тусгай тунгаагуур, цэвэр усны сан хоёроор дамжуулан цэвэршүүлэн тунгалагжуулдаг тул үйлдвэрлэлийн технологийн хаягдал бохир ус гардаггүй. Харин ажиллагсдын унд ахуйн болон ариун цэврийн өрөө, халуун усны хэрэглээнээс гарсан бохир усыг хотын ариутгах татуургын нэгдсэн сүлжээнд нийлүүлэн хаядаг. Үйлдвэрийн газарт хамаарах бохир усны сүлжээний нийт урт 0,6 км. Энэ сүлжээгээр хоногт 3,8 м³ буюу жилд дунджаар 1,368 мян.м³ бохир зайлуулагдах бөгөөд хаягдаж байгаа ус нь зөвхөн ахуйн бохирдолтой юм.

Үйлдвэрийн дулааны хангамж: Үйлдвэрийн харъяа дулааны станц нь өөрийн үйлдвэрээс гадна Сайхан сумын Хөтөл хотыг дулаанаар ханган ажиллаж байна.



Шуудан холбоо: Хөтөлийн “Цемент-Шохой” ТӨХК нь Улаанбаатар хот болон бусад аймаг, гадаад орнуудтай шууд харилцах телефон холбоотой, мэдээллийг факсаар солилцох бүрэн боломжтой.

Шохойн үйлдвэрлэл

Чулуунцар үйлдвэрлэл нь автоматжуулсан үйлдвэр ба хоногт 2500 тонн чулуунцар үйлдвэрлэх хүчин чадалтай.

Хос роторт бутлуур	900 тонн/цаг
Шохойн чулууны жигдрүүлэх агуулах	73,000 тонн
Булт тээрэм	210 тонн/цаг
Эргэх зуух Ø4м, 60м	2,500-3,000 тонн/цаг
Нүүрсний тээрэм	18-20 тонн/цаг
Нүүрсний жигдрүүлэн нуруулдах агуулах	15,000 тонн
Цементийн тээрэм 3ш	3х50 тонн/цаг
Цементийн силос	16,000 тонн
Цементийн савлах машин 3ш	300 тонн/цаг

Шохойн үйлдвэрлэл нь жилд 65 мян.тн шохой үйлдвэрлэх хүчин чадалтай. Тус цех нь хоногт 70 тн бүтээмжтэй ажиллах шохойн чулууг шатаах 3 зуухтай. 0-3 мм ширхэглэлээр нарийн бутлагдсан 70%-иас доошгүй идэвхжилтэй шохойг жилд 65 мян.тн гаргахаар төлөвлөсөн бөгөөд эхний жилүүдэд нунтаг шохой, сүүлийн жилүүдэд 80%-иас доошгүй идэвхжилтэй бүхэл шохойг үйлдвэрлэн Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-т нийлүүлж байна.

1.2 Шохойн чулууны орд

1961 онд Дарханы районд хийгдсэн 1:200000 масштабтай эрэл зураглалын ажлаар Орхон голоос зүүн урагш 25км-т протерозойкембрийн элсэн чулуу, занарын

“Цемент Шохой” ТӨХК

дунд шохойн чулууны линз хэлбэрийн биетийг илрүүлсэн. 1962 онд тус районд хийгдсэн 1:25000 масштабтай эрлийн ажлын үр дүнд шохойн чулууны хэд хэдэн линз илрүүлсэн. Линз ирүүлснээс Хөтөлийн шохойн чулууны орд юм. Шохойн чулуу нь суналын дагуу 2750м баруун урагшаа 45-50 градус суналттай, биетийн зузаан нь 100м гэж тогтоожээ. Мөн 2014 онд Андреев А.А шохойн чулууны илэрц дээр геологийн урьдчилсан хайгуулын ажил хийж ордын төв хэсгийг В-С1 зэргээр зүүн ба баруун жигүүрийг С1-С2 зэргээр нөөцийг тогтоосон.

Орд нь геологийн тогтоцын хувьд хувиралд орсон элсэн чулуу, занар, шохойн чулуунаас тогтох бөгөөд профиритын дайкар хэрчигдэж дөрөвдөгчийн сэвсгэр хуудсаар хучигдсан байна.

Хөтөлийн шохойн чулууны орд нь структурын харьцааны хувьд антикналь атираажлийн өмнөд жигүүрийн хэсэгт профиритын дайга болон тектоникийн эвдрэлтэй орон зайн хувьд холбоотойгоор үүссэн. *Ордын геологийн литологийн зүсэлтийг үзүүлбэл:*

1. Элсэн чулуу бараан саарал өнгөтэй, янз бүрийн ширхэглэлтэй уналтын азумит 170-190°
2. Шохойн чулуу саарал өнгөтэй, гантигжсан, доломитлогжих процесс орсон, СаО 34%, MgО 14%, хурдасны зузаан 30м. Занар хлоржих процесст орсон ногоовтор туяатай, бараан саарал өнгөтэй, үзэгдэх зузаан нь 20-30м.
3. Шохойн чулууны доод дээд хэсэг нь цайвар саарал өнгөтэй, гантигжсан зузаалгын дунд хэсэгт нь саарал өнгөтэй, жижиг ширхэгтэй шохойн чулуу, доломитжих процесст бага зэрэг орсон MgО-1.5-3.0%.
4. Хурдаслаг чанар хлоржих процесст орсон ногоовтор өнгөтэй, бараан саарал туяатай, үзэгдэх зузаан нь 100м шохойн чулууны үеийг хучиж байрласан. Ордын нийт талбай нь элсэн чулуу, занар, шохойн чулууны хэмхдэс материал агуулсан боровтор саарал өнгийг дөрөвдөгчийн хурдасаар хучигдсан байна. Энэ хурдасны зузаан нь 0.5-12м.

Шохойн чулууны орд нь засаг захиргааны хувиарлалтаар Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт “Шохойн нуруу” хэмээх газарт байрлах ба ашиглалт явуулах 12219А, 15249А тоот зөвшөөрлийн талбайд байрлана.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2016 онд хийлгэж БОАЖЯ-аар баталгаажуулсан.

Тус орд нь газар зүйн байрлалаараа Монгол орны Хангайн уулын бүсэд хамаарагдах ба, далайн түвшнээс дээш 1000-1500 м өндөрт өргөгдсөн хэсэгт оршино.

Хөтөл-1 ордын шохойн батламжлагдсан үйлдвэрлэлийн нөөц 1980 оны 11-р сарын 3-ны байдлаар В+С1 зэрэглэлээр 47,6 сая.тн, үүнээс шохойн түүхий эд 14,8 сая.тн, ба цементийх 32,8 сая.тн болно. Төмөртолгойн ордын төмрийн хүдрийн нөөц В+С1 зэрэглэлээр 3,7 сая.тн байгаа нь тус үйлдвэрийг 50 жил хангахад хүрэлцээтэй юм. Тус заводын хэрэгцээнд зориулсан шохойн чулууны ил уурхайн хүчин чадал жилд 1015 мян.тн, үүнээс 790 мян.тн нь шохой, цемент болон товарын шохойн чулуу

“Цемент Шохой” ТӨХК


үйлдвэрлэх сайн чанарын шохойн чулуу бөгөөд 225 мян.тн нь цемент үйлдвэрлэлийн зориулалттай карбонат багатай шохойн чулуу байна.

Урьдчилсан хайгуулыг явуулахдаа баганат өрөмдлөг, суваг, шурф малталтын ажил хийж, нөөцийг +940-р түвшин хүртэл тогтоожээ. Тус ордыг түшиглэж жилдээ 500.0мян.тн 400 маркийн портланд цемент үйлдвэрлэх хүчин чадалтай цементийн үйлдвэр, 65мян.тн шохой үйлдвэрлэх хүчин чадалтай шохойн үйлдвэр барих болсонтой холбогдуулан 1975-1976 онд барилгын материалын экспедицийн №7 анги нарийвчилсан хайгуул хийсэн.

Шохойн чулууны ордыг геологийн тогтоц хэмжээ чанараас хамааруулж 2-р группт хамааруулжээ. Хайгуулын шугмуудын хоорондын зайг В зэргээр нөөц бодсон талбайд 90-160м–р С1 зэргээр нөөц бодсон талбайд 180-340м-р авчээ.

1976 онд Хөтөлийн шохойн чулууны орд дээр 23 цооног буюу 2035 уртааш метр өрөмдлөгийн ажил хийжээ. 1980 онд Ш.Доржсүрэн, К.Ш.Фаткуллан, С.Н.Кальсан нар 1962-1963, 1975-1976 онуудын урьдчилсан болон нарийвчилсан хайгуулын ажлын тайлангийн материал хими шинжилгээний үр дүнг үндэслэн барилгын шохой үйлдвэрлэх чиглэлээр нэмэлт судалгаа хийж гүйцээх судалгааны тайлан бичсэн байна. Үүний үр дүнд ордын нөөцийг 1980 оны 01-р сарын 01-ний байдлаар УАМНК-оор батлуулжээ. Ордыг ашиглах явцад 1980 оны дээрх батлагдсан нөөцийн чанар, тоо хэмжээ, хил хязгаарт өөрчлөлт их хэмжээгээр гарч, нөөц тооцож үйлдвэрийг түүхий эдээр хангахад хүндрэл учирснаас тэр үеийн үйлдвэрийн захиргаа 1988 онд Улсын Барилгын Хороонд /УБХ/ Хөтөл-1 ордын төв хэсэгт гүйцээх хайгуул, нөөц Хөтөл-2 ордод нарийвчилсан хайгуул хийлгэх хүсэлт тавьснаар уг ордын ашиглалт эхэлсэн.

1992 онд Эрдэнэтийн УБҮ-ийн хайгуулын ангид ашиглалтын хайгуул хийлгэх захиалга өгч дээрх захиалгын дагуу ордын төв хэсэгт хайгуулын шугам 1-ээс 22-ын хооронд өөрөөр хэлбэл ордын баруун талын II шугмаас зүүн талын III шугмын хооронд +930-р түвшин хүртэл нарийвчилсан хайгуулын схемээр ашиглалтын хайгуул өөрийн хөрөнгөөр хийж ойрын жилүүдэд ашиглах ашигт малтмалын геологийн тогтоц, тоо хэмжээ, хил хязгаарыг тогтоож, нарийвчилсан хайгуулын нөөцийн баталгааг дүгнэж, тодруулах боломжтой болсон.



2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Энэхүү газар нутаг нь хөрс газарзүйн мужлалтын хувьд био уур амьсгалын Төв Азийн их мужийн Хангай Хэнтийн өмнөдийн дэд мужид хамаарна. Энд хуурай хээрийн тал, хотгор, жижиг цав толгодын нунтаг карбонатлаг хар хүрэн, уугуул хэлбэрийн чулуурхаг нимгэн ба гүйцэд хөгжилтэй хөрс зонхилно.

Харин шохойн чулууны орд нь тектоникийн хөдөлгөөнөөр уулын цул газрын гадаргад ил гарч бутран тархасны улмаас гүвээ толгод хэлбэртэй гадаргуу болон тогтжээ. Энэ гадаргуугийн чулуулгийн зай, завсар элэгдэл, хуримтлалаар дүүрч өнгөн хөрс бүрдэх нөхцөл болсон байна. Иймээс ордын дээр бүрэлдэн тогтсон хөрсний зузаан янз бүр зарим хэсэгт 1.5м байхад зарим газартаа 5 м хүртэл зузаантай байдаг байна. Энэ хөрс нь механик бүрэлдэхүүнээрээ шавранцар бөгөөд хүчиллэг талст чулуулаг дээрх уулын хүрэн хөрсөнд тооцогдоно.

Жалга хөндийн хэсгээр элэгдэл хуримтлалын шинжтэй, усны зөөгдлөөр үүссэн хөрсөн бүрхэвч зонхилно. Уурхайн ухсан хэсгээс хөрсний тогтоцыг үзэхэд эндэхийн хөрсний шилжилт нь тод ялгаран харагдах бөгөөд ерөнхийдөө гурван үе давхаргаас тогтсон байна. Үүний дээд хэсэг нь тоосорхог, хөнгөн цавранцар механик бүрэлдэхүүнтэй, азот, фосфорын хангамжаар муу, калийн хангамж дунд зэрэг, хөрсний уусмалын орчин саармаг, ялзмагийн хэмжээ багавтар давсжаагүй, ургамлын үндэсээр баяраг байхад дундах үе нь тоосорхог шавар механик

“Цемент Шохой” ТӨХК

бүрэлдэхүүнтэй, маш их давсжсан, сульфатын ион зонхилсон, хөрсний уусмалын орчин сул шүлтлэг цайвар бор өнгийн хөрс байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү төлөвлөгөөний гол зорилт нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах байлаа.

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж ажиллаж байна.

Цемент, шохой үйлдвэрлэх технологийн үе шатуудад орчинд утаа, тоосжилт үүсгэх сөрөг нөлөөлөлтэй.

Иймд бид Сэлэнгэ аймгийн Цаг уур орчны шинжилтгээний газартай гэрээ байгуулан агаар, хөрсний шинжилгээг тогтмол хийлгэж ирсэн ба шинжилгээний дүнгээр илэрсэн сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна.

“Цемент Шохой” ТӨХК нь 2022 онд Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн болно.

Үүнд:

- **Агаарын чанар:** 2022 оны 5,8,9 саруудад /3 удаа / Сэлэнгэ аймгийн Цаг Уур Орчны шинжилгээний газраас 2 хүний бүрэлдэхүүнтэй лаборатори шинэжээч үйлдвэрийн хашаан дотроос гэрээнд заагдсан 5 цэгээс агаарын шинжилгээний дээжийг авч тухай бүр хариуг ирүүлсэн болно. Шинжилгээгээр азотын давхар исэл, хүхэрлэг хий, нийт тоосны хэмжээг тодорхойлдог ба бүх үзүүлэлтүүд MNS4585:2016 стандартад заагдсан хүлцэх агууламжаас хэтрээгүй дүгнэлт гарсан.
- **Ус:** Үйлдвэрийн шугамын усыг 2022 оны 5 болон 9-р саруудад буюу нийт 2 удаа шинжилгээнд хамруулсан ба Сэлэнгэ аймгийн Ус Цаг Уур Орчны шинжилгээний албаны Байгаль орчны лабораторид шинжлүүлээ. Уг шинжилгээний дүнд усны химийн чанарын ихэнх үзүүлэлтүүд нь ундны усны MNS 900:2005 стандартын хэмжээнд байсан. Усны хатуулгийн агууламж нь тогтвортой хатуулагтай усны ангилалд хамрагдаж байна.
- **Хөрсний чанар:** Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хөрсний хяналт шинжилгээг 2022 оны 5



“Цемент Шохой” ТӨХК

болон 9-р саруудад Сэлэнгэ аймгийн Цаг Уур Орчны шинжилгээний газрын Байгаль орчны лабораторитай байгуулсан гэрээний дагуу 2 удаа явуулсан.

Үйлдвэрийн нөлөөллийн хэсэг болон үйл ажиллагаатай уялдуулан үйлдвэрийн хашаан дотроос 3, гадна талаас 2 хөрсний дээжийн хяналтын цэгийг сонгож, шинжлүүлсэн.

Дээрх цэгүүдээс хөрсний дээж авч агрохимийн шинжилгээ хийхэд хөрсний ялзмагийн хэмжээ үйлдвэрийн хашаан дотор бага байсан ба хөрсний урвалт орчин



шүлтлэг байлаа.

Бид хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж ажиллаж байна.

Хөтөлийн Цемент Шохойн үйлдвэр ба шохойн чулууны ордод сөрөг нөлөөллийн үйл ажиллагааг хамтад нь дараах байдлаар гүйцэтгэсэн болно.


Үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэж буй сөрөг нөлөөллийг бууруулахын тулд тухайн районд ногоон байгууламжыг сайжруулах, нөхөн сэргээлт болон орчны усалгаа, тохижилтын ажлыг жил бүр Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

“Цемент Шохой” ТӨХК-ийн шохойн чулуу олборлох үйл ажиллагааг ТЭЗҮ-д тусгасны дагуу хэрэгжүүлж байгаа ба ТЭЗҮ-ний шинэчилсэн хувилбарыг 2016 онд Ашигт Малтмалын газар баталгаажуулсан болно.


“Цемент Шохой” ТӨХК

“Цемент Шохой” ТӨХК нь 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд нийт 46,135,300 (дөчин зургаан сая нэг зуун гучин таван мянга зурван зуу) төгрөг төсөвлөсөн байна.

Цемент Шохой ТӨХК-ний биологийн нөхөн сэргээлт хийх талбайн зураг



Цемент Шохой ТӨХК-ний техникийн нөхөн сэргээлт хийх талбайн зураг



“Цемент Шохой” ТӨХК

“Цемент Шохой” ТӨХК-ийн 2016 оны Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний үйлдвэрийн нэмэлт тодотголын тайлан, Хөтөл-1, 2 шохойн чулууны ордод хийсэн БОНБНҮнэлгээний тайлан болон 2020 онд гүйцэтгүүлсэн Байгаль орчны аудитын тайлан, Газрын хянан баталгааны тайлан, ҮАБ-ын шалгалтын зөвлөмжийн дагуу тус тус үндэслэн гаргасан төлөвлөгөөний дагуу ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

2022 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

№	Уулын ажил	Гүйцэтгэгч байгууллага	Хэмжих нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Өрөмдлөг	УАТЦех	у.метр	56300	32911	-23389	58%
2	Хөрс хуулалт	УАТЦех	м3	708000	454376	-253624	64%
3	Шохойн чулуу олборлолт	УАТЦех	тн	1258000	675614	-582386	54%
4	Сланц олборлолт	УАТЦех	тн	82500		-82500	0%
5	Уулын цул	УАТЦех	м3	1206327	705534	-500793	58%
6	Хөрс хуулалтын этгэлцүүр	УАТЦех	м3/тн	0.56	0.67	0.11	119%

(Эхний 10 сарын байдлаар)

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Агаарын чанар

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөлийг арилгах, бууруулах арга хэмжээ	Гүйцэтгэл
1	Үйлдвэрлэлтийн явцад агаарыг бохирдуулах сөрөг нөлөөлөл	Агаарын чанарын дотоод хяналтыг тогтмол явуулах /ОХШХ-өөс харах/	Сэлэнгэ аймгийн УЦУОШАлбатай байгуулсан гэрээний дагуу 2022 оны 5, 8,9-р саруудад шинжилгээ хийлгүүлэхэд эхний саруудад стандартын дагуу байсан бол сүүлийн сарын шинжилгээний хариу хүлцэх агууламжаас их гарсан. /Хавсралт №1/
2	Агаарын бохирдлоос үүсэлтэй ажилчдад учрах сөрөг нөлөө	Үйлдвэрийн бүх ажлын байруудын эрүүл ахуйн нөхцөлд хяналт тавих /ОХШХ-өөс харах/	Тоосны хэмжээ ихтэй ажлын байруудад “Юнител” ХХК-тай хамтран Агаарын чанар шалгах хяналтын багаж суурьлуулсан. /Хавсралт №2/
3	Агаарын тоосжилтын сөрөг нөлөөлөл	Технологийн үйл ажиллагаа явагдах замуудад усалгааг тогтмол хийх	Усалгааг батлагдсан графикийн дагуу технологийн зам талбайг 7 хоногийн 7 өдөр өглөө 08-20 цаг хүртэл тогтмол услаж, зам талбайд үүсэх тоосжилтыг бууруулж ажилласан. /Хавсралт №3/
4	Үйлдвэрлэлийн явцад тоног төхөөрөмжөөс гарч буй утааны нөлөө	Тоног төхөөрөмжийн дотоод шаталтат хөдөлгүүр болон халаалтын том, жижиг	Цементийн үйлдвэр, Чулуунцарын үйлдвэрийн цахилгаан фильтрийн тоосонцор шүүх уутнуудыг нормын дагуу сольж ажиллаж байна.

“Цемент Шохой” ТӨХК

		оврын зуух, цахилгаан үүсгүүрийн хаягдал утаанд хорт хий, тоос багасгах шүүлтүүр тавих, утааны шүүлтүүрийг тогтмол солих	/Хавсралт № 4/
5	Хаягдал нунтаг шохойны агаарт дэгдээж буй нарийн тоосонцорын сөрөг нөлөө	Шохойн үйлдвэрийн гаднах хаягдал чулуулгийн овоолгын үлдэгдлийг үйлдвэрлэлд ашиглаж орчныг цэвэрлэх	Олон жилийн үйлдвэрлэлийн явцад хэт ба дутуу шаталтаас үүссэн хаягдал нунтаг шохой (Козэль)-г 2015 оноос эхлэн технологийн орц, норм, картын дагуу үйлдвэрлэлд дахин ашиглаж, байгаль орчинд шууд хаягдах хаягдлыг бууруулж ажиллаж байна. /Хавсралт №5/
6	Шохой үйлдвэрлэлтийн явцад гарч буй сөрөг нөлөө	Шохойн чулуу шатаах явцад гарч буй хий, тоос тоосонцор агаарт дэгдсэнээр учирч болох аюул, эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх, үүссэн тохиолдолд ямар замаар хамгаалах, арилгах талаар ажилчдыг сургалтанд хамруулж, мэдлэгийг дээшлүүлэх	2022 оны 01-р сарын 03-ны өдрийн А/01 тушаалаар “Нийт ажилчдын сургалт”-ыг 1-2-р саруудад зохион байгуулсан. Байгаль орчны сургалтад агаарын бохирдлын эх үүсвэр, түүнийг бууруулах чиглэлээр ажилтнуудад мэдлэг олгосон. /Хавсралт №6/
7	Орчны тоосжилтоос үүсч буй сөрөг нөлөөлөл	Салхи, шуургатай үед тоос шороо зөвшөөрөгдөх хэмжээнээс их байгаа зам, талбай, овоолгуудыг услах	Чийгшүүлэх шаардлагатай зам талбайг усалгааны графикийн дагуу тогтмол усалдаг. /Хавсралт №3-тай давхацсан/
8	Техник болон тээврийн хэрэгсэлүүдээс гарч буй сөрөг нөлөө	Тээврийн хэрэгслүүдийг тогтмол үзлэг, оношлогоонд хамруулж, тээврийн хэрэгслээс ялгарах утаанд хяналт тавьж ажиллах, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	2022 оны үзлэг оношлогоонд нийт тээврийн хэрэгслүүдийг хамруулж, засвар хийх талбайг хатуу хучилттай болгож засвар үйлчилгээг тогтмол хийж байна. /Хавсралт №7/
9	Технологийн ажил явагдаж байх хугацаанд үүсэж байгаа нөлөөлөл	Тэсэлгээ хийх, хөрс хуулах үеийн байршлуудын салхи ихтэй үеүдэд сул шороо ихтэй зам талбайн гадаргыг чийгшүүлж байх	Чийгшүүлэх шаардлагатай хэсгүүдэд усалгааг тогтмол хийж гүйцэтгэдэг.

Гадаргын ба газрын доорх усны нөөц

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Гүйцэтгэл
1	Газрын доорх усны нөөцөөс үүсэх хомсдол	Ус ашиглах дүгнэлт гаргуулах	“Усны газар” МУЗГХА-аар 2022.05.19-ны өдөр 01/586 тоот ус ашиглах дүгнэлт гаргуулсан. /Хавсралт №8/
2	Ундны усанд гарах нөлөөлөл	Усны эх үүсвэрүүдийн худгуудаас жилд 2 удаа дээж авч, ундны усны химийн бүрэн шинжилгээ хийх, жилд 2 удаа дээж авч хүнд металлын бохирдол тодорхойлох, ахуйн болон үйлдвэрээс гарах бохир усыг цэвэрлэсний дараа жилд 2 удаа дээж авч, ундны усны химийн бүрэн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах	2022 онд 2 удаа Сэлэнгэ аймгийн УЦУОШАлбаны Байгаль орчны лабораториор ундны болон ахуйн усыг шинжлүүлж шинжилгээ хийлгэсэн. /Хавсралт № 9/
3	Үйлдвэрийн хэмжээнд унданд хэрэглэж буй усны сөрөг нөлөө	Шинжилгээний үр дүнг ундны болон цэвэр, бохир усны стандарттай харьцуулж, зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан тохиолдолд хариу арга хэмжээ авч байх	Сэлэнгэ аймгийн УЦУОШАлбаны Байгаль орчны лабораториор ундны болон ахуйн усыг шинжлүүлж шинжилгээ хийлгэсэн. /Хавсралт № 10/
4	Гүний усны ундаргад үүсэж буй нөлөө	Гүний усны нөөц, чанарт байнгын хяналт тавьж, түвшний хэмжилт, дээжлэлт хийж, баримтжуулах	Гүний усны ундаргыг баталгаатай тоолуурын заалтыг үндэслэн хэмжилт хийдэг. /Хавсралт №11/
5	Хатуу, шингэн хаягдлаас үүдэлтэй сөрөг нөлөө	Уурхайн ойр орчим хатуу ба шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүн хаяхгүй байх	Уурхай орчим ил задгай хог хаягдал хаяхгүй байх талаар сургалт ордог. 7 хоног бүр үзлэг шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулж ажилладаг. Мөн Сэлэнгэ аймгийн УЦУОШАлбаны Байгаль орчны лабораториор уурхайн орчны хөрснөөс дээж авч нэфтийн бүтээгдэхүүнийг шинжлүүлсэн. /Хавсралт № 12/

“Цемент Шохой” ТӨХК

Хөрсөн бүрхэвч

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах,бууруулах арга хэмжээ	Гүйцэтгэл
1	Үйлдвэрийн бүс нутгийн хөрсөнд нөлөөлж буй сөрөг нөлөө	Хөрсөнд агуулагдах хүнд хортой элементийн агууламж, агрохимийн үзүүлэлтүүд, Нефтийн бүтээгдэхүүн тодорхойлох	Сэлэнгэ аймгийн УЦУОШАлбаны Байгаль орчны лабораториор уурхайн ойр орчмын хөрсөнд хүнд металл, агрохимийн үзүүлэлтийн шинжилгээг 05, 09-р саруудад хийлгүүлсэн. /Хавсралт № 13/
2	Хөрсний элэгдэл, эвдрэх сөрөг нөлөө	Технологийн үйл ажиллагаа явагдах замууд ба нүүрс буулгах талбай, бетонон хучилтгүй хэсэг талбайд усалгааг тогтмол хийх	Усалгааг тогтмол хийж тоосжилтыг бууруулж ажилласан.
3	Хөрсний бохирдол, элэгдэл үүсэх сөрөг нөлөө	Шатах, тослох материал хадгалах, засвар хийх талбайг үер, галын аюулд өртөхөөргүй газарт сонгон байрлуулж, шатах тослох материал санамсаргүй тохиолдлоор асгарахаас урьдчилан сэргийлж элс, хайрган хучилт хийж өгч, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ хийж байрлуулах	Шатах, тослох материал хадгалах, засварын талбайг хатуу хучилттай талбайд байрлуулсан. Галын буланд эрсдлийн үнэлгээг тогтмол хийж, бэлэн байдлыг ханган ажиллаж байна. /Хавсралт № 14/
4	Орчны эрүүл ахуй алдагдах сөрөг нөлөө	Ахуйн гаралтай хатуу хог хаягдлыг агаар, ус чийг, салхинаас бүрэн хамгаалах түр хураан хадгалах байр сав байгуулах, тэмдэгжүүлэх, ухуулах самбар байрлуулах, тогтмол хугацаанд хогийн нэгдсэн цэгт тээвэрлэж хаях	Ахуйн хог хаягдлыг түр хураан хадгалах байр саванд цуглуулдаг ба сумын Хот тохижилтын газартай байгуулсан гэрээний дагуу хогийн цэгт тээвэрлүүлдэг./Хавсралт № 15/
5	Хөрс талхлагдах сөрөг нөлөө	Авто зогсоолыг болон шохойн чулууны уурхайн талбайн дотор ба гадна орчны авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зохицуулах тэмдэг, тэмдэгжүүлэлт хийх	Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зохицуулах тэмдэг, тэмдэглэгээтэй.
6	Хөрсний бохирдол үүсэх сөрөг нөлөө	Уурхай дээрх засварын төвийн хаягдал тосыг автобаазын хатуу хучилттай талбайтай нэгтгэх, төмрийн хаягдлыг цэгцлэх	Уурхай дээрх ажилласан тосыг Хуурай аргын үйлдвэрийн хатуу хучилттай ажилласан тос хадгалах байранд зөөвөрлөн хадгалж байна. /Хавсралт № 17/

“Цемент Шохой” ТӨХК

7	Хөрсний физик шинж чанар алдагдах сөрөг нөлөө	Техникийн засвар, үйлчилгээг авто граш дотор тогтмол явуулж байх	Техникийн засвар үйлчилгээг зориулалтын хатуу хучилттай авто граш дотор явуулдаг.
8	Хөрс бохирдохоос сэргийлэх	Зөөврийн шатахуун түгээх станцаас хөрсний болзошгүй бохирдол үүсэхээс сэргийлж ашиглахгүй байх	Зөөврийн шатахуун станц ашиглаагүй.

Газрын хэвлий

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Гүйцэтгэл
1	Химийн хортой болон аюултай бодисын сөрөг нөлөөлөл	Хаягдал ангилан хадгалах буюу химийн хорт болон аюултай бодис хадгалах талбай, засвар үйлчилгээний цех орчим хөрсөнд агуулагдах хүнд хортой элементийн агууламжийг тодорхойлж, Монгол улсад дагаж мөрдөж байгаа стандарт үзүүлэлттэй харьцуулан үнэлэлт дүгнэлт өгөх, цаашлан хяналт тавьж ажиллах	Сэлэнгэ аймгийн УЦУОШАлбаны Байгаль орчны лабораториор 5, 10-аар саруудад шинжилгээ хийлсэн. /Хавсралт № 13-тай давхцаж байна/

5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Үйлдвэрлэлийн хаягдал хуримтлуулсан 3га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	MNS 5917:2008
2	Биологийн нөхөн сэргээлт	2021 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн доторлогооны тоосго хуримтлуулсан талбайд зүлэгжүүлэлт хийх	MNS 5918:2008

5.1 ТЕХНОЛОГИЙН ХАЯГДАЛ ХУРИМТЛАГДСАН ТАЛБАЙ ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ:

“Цемент Шохой” ТӨХК-ийн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан технологийн хаягдал хуримтлагдсан 3,0 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 7,8,9-р саруудад гүйцэтгэж дуусгасан.

Төлөвлөгөөний дагуу технологийн хаягдал хуримтлуулсан 3,0 га талбайд олон жилийн турш хуримтлагдсан, дахин ашиглагдахгүй технологийн хаягдлуудыг үйлдвэрлэлийн түр хадгалах отвалруу зөөж талбайг чөлөөлөх байдлаар техникийн нөхөн сэргээлт хийж, тухайн талбайг үржил шимт хөрсөөр хучин тэгшилж, ирэх жилийн биологийн нөхөн сэргээлтэд газрыг бэлдсэн.



Өмнө

Дараа

Шимт хөрс асгасан байдал

5.2 БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ:

2022 оны биологийн нөхөн сэргээлтэнд тусгагдсаны дагуу хавар 3 дугаар сард ажил эхэлмэгц 3,3 га талбайг, үйлдвэрлэлийн технологийн ажлын завсраар нөхөн сэргээлтийн талбайд шимт хөрс буулгах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Шимт хөрс буулгаж дууссаны дараа талбайг тэгшилж, 6 дугаар сарын 16-нд зүлэгжүүлэлтийн ажлыг MNS6260:2020 стандартын дагуу 1м² талбайд 20гр үрийг МТБ80-маркын трактор болон ОМИЧК-2,1 силк үрлэгчээр зүлэгжүүлэлтийг хийж ажлыг 100% гүйцэтгэж ажилласан.



Талбай дээр шимт хөрсийг дэвссэн



МТБ80 маркын трактор, ОМИЧК-2,1
слик үрлэгчээр согоовор үр засаж
байгаа



7-р сарын байдлаар Биологийн нөхөн
сэргээлт хийсэн талбайн ургалтын явц



Талбайд усалгаа хийж буй байдал

6. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар бүлгийн 5.1.8-д “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8000 га талбайг нөхөн сэргээнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн БОАЖГ-аас 2022 оны 03 сарын 02-ны өдрийн 81 тоот албан бичиг ирүүлсэн. Уг албан тоотод Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт эвдэрч олон жил орхигдсон нөхөн сэргээлт хийгээгүй

49 24 9.73 107 23 28.68

49 24.5.48 107 23 23.66

49 24.15.07 107 23 12.31

49 24 18.17 107 23 20.79 солбилцол бүхий эвдрэлд орж эзэнгүй орхигдсон 6 га талбайд холбогдох журам, стандартын дагуу талбайн нөхөн сэргээлтийг ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж, байгууллагын тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлыг

“Цемент Шохой” ТӨХК

дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд төлөвлөн гүйцэтгүүлэх, хамтран ажиллах саналыг тусгасан. 2022 оны БОМТөлөвлөгөөний “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд” бичил уурхайн улмаас эвдрэлд орсон газрын техникийн нөхөн сэргээлтийг MNS 17.5.1.19-92, MNS 5917-2008 стандартын дагуу хийж гүйцэтгүүлэхээр “Хишигтэн Залуус” ХХК-ийг сонгон шалгарч, ажлыг хийж дуусгасан.

2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний ажилд 158,555,606 төгрөг зарцуулсан.



Техникийн нөхөн сэргээлт хийгдэхээс өмнөх талбай



Техникийн нөхөн сэргээлт хийгдэж дууссан талбай

7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Ашигт малтмалын тухай хуулийн 41-р зүйлийн 41.1-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна” гэж заасан.

Гэвч Хөтөлийн “Цемент Шохой” ТӨХКомпанийн эзэмшиж буй газарт малчид болон орон нутгийн иргэдийн газар эзэмших эрхийн гэрчилгээтэй намаржаа, өвөлжөө, хаваржааны байршил байхгүй юм. Тиймээс нөхөн олговрын асуудал байна.

8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Монгол улсын “Соёлын Өвийг Хамгаалах Тухай” хуулийн 6-р бүлгийн 17-р зүйлийн 10-т “Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа урьдчилан хайгуул судалгаа хийлгэж, түүнээс зөвшөөрөл авна” гэж заасны дагуу ШУА- ийн Археологийн хүрээлэнгийн археологийн хайгуул судалгааны баг Хөтөлийн “Цемент- Шохой” ТӨХК- ийн Сэлэнгэ аймгийн Орхон сумын нутагт орших “Хөтөл- 2” нэртэй ашигт малтмал ашиглалтын 15249А тоот тусгай зөвшөөрөлтэй, 61.46 га талбайд 2013 оны 08 дугаар сарын 20-ны өдөр гүйцэтгэж 2013 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 01/180/а.а тоот дүгнэлтийг гаргасан байна. Уг дүгнэлтэнд хайгуул судалгааны явцад 1 дурсгал илрүүлсэн ба үүнийг Монголын түүхэн үед холбогдох булш оршуулгын дурсгал хэмээж тус талбайд мэргэжлийн байгууллагаар малтлага судалгаа хийлгэх шаардлагатай хэмээн үзсэн тул ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй хамтран ажиллах АГГ/14/76 тоот гэрээг 2014 оны 7 сарын 31-ний өдөр байгуулсан. Тус гэрээний дагуу 2014 оны 8 сард Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт орших цемент, шохойн уурхайн хөрс хуулалтын ажилд өртөх магадлалтай 1 дурсгалыг авран хамгаалах малтлага судалгааны хээрийн ажлыг гүйцэтгэлээ. Тус судалгаанд хамрагдсан дурсгал нь Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт сумын төвөөс зүүн урд зүгт 4 км зайд буюу уурхайн талбайд байрлаж байлаа. Энэхүү судалгааны туршид уурхайн ашиглалтын явцад өртөж болзошгүй байсан нэг дурсгалыг малтан судалж талбайг чөлөөлсөн болохыг Археологийн авран хамгаалах малтлага судалгааны тайланд дүгнэсэн байна. Одоог хүртэл түүх, соёлын өв дахин олдоогүй.

9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

/Химийн бодисын эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх менежментийн төлөвлөгөөний тайлан/

№	Гүйцэтгэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн	Тайлангийн биелэлт
1	Химийн эрсдлийн үнэлгээ хийлгэх	2022 онд	СШЛабораторийн эрхлэгч, Инженер аналитик, техникийн менежер	БОННУ-нд нэг бүлэг болгон оруулсан.
2	Хадгалж байгаа химийн хорт болон аюултай бодисын сав, баглаа боодол дээр тухайн бодисын нэр анхааруулах тэмдэг, аюулын шинж чанарыг харуулсан тод, том шошго зэргийг шинэчлэн хадаж байрлуулах	2022 онд	СШЛабораторийн эрхлэгч, Инженер аналитик, техникийн менежер	Сорилт шинжилгээний лабораторид нийт 71 төрлийн химийн бодис ашиглагддаг. 2016 оны БОННУ-нд ХАЛМ-аар ангилж химийн бодисын эрсдлийн үнэлгээ хийлгэсний дагуу хаяг

“Цемент Шохой” ТӨХК

				шошгийг хажуу хандаж байрлуулсан.
3	Химийн хорт болон аюултай бодис хадгалах складыг зохих журмын дагуу ашиглаж, тогтмол хараа хяналттай, цоожтой байлгаж, хаалгыг лацдах.	2022 онд	СШЛабораторийн эрхлэгч, Нярав	Сар бүр химийн бодисын ашиглалтын тайланг авдаг. /Хавсралт №18/
4	Химийн хорт болон аюултай бодис ашиглахтай холбоотой үйл ажиллагааг хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбайд явуулах	2022 онд	СШЛабораторийн эрхлэгч, Инженер аналитик, техникийн менежер	Цемент Шохой ТӨХК нь Сорилт шинжилгээний лабораторитай. Зориулалтын байр талбайд шаардлагыг бүрэн хангаж ажилладаг болно.
5	Ажлын байран дээр ашиглагдаж байгаа химийн бодисуудыг хадгалж буй шүүгээ нь бат бөх болон хэт олон бодис дүүртэл хадгалсан эсэх, тавиур дээрх химийн бодисыг хана болон шаланд сайтар бэхлэгдсэн эсэхийг шалгаж аюулгүй байдлыг хангах	2022 онд	СШЛабораторийн эрхлэгч, Инженер аналитик, техникийн менежер	Сар бүр ХАБ-ын Инженер, ИТА нартай хамтран үзлэг шалгалт хийж хяналт тавин төлөвлөгөө тайланг авдаг. /Хавсралт №19/
6	Химийн хорт болон аюултай бодистой харьцаж ажилладаг ажилтан нарт болзошгүй осол, эрсдлээс сэргийлэх, анхны тусламж үзүүлэх сургалтыг зохион байгуулах	2022 онд /хагас жилд 1/	СШЛабораторийн эрхлэгч, Инженер аналитик, техникийн менежер	2022 оны 2-р сард анхны тусламж үзүүлэх сургалтыг зохион байгуулсан.
7	Химийн хорт болон аюултай бодисын зарцуулалтын бүртгэл хөтөлж, тайлан, мэдээг Сайхан сумын Засаг даргад жил бүрийн 12-р сарын 15-ны дотор, Сэлэнгэ аймгийн БОАЖГ, БОАЖЯам руу тус тус дараа оны 1-р сард хүргүүлэх	2022 онд	СШЛабораторийн эрхлэгч, Инженер аналитик, техникийн менежер	Тайланг сар, улирлаар нь гаргаж явуулсан болно. /Хавсралт №20/
8	Химийн хортой бодисын хуванцар сав, аюултай хог хаягдлыг тухай бүрт гэрээт байгууллагад хүргүүлж, устгуулах	2022 онд	Үйлдвэрийн хэмжээнд	Аюултай хог хаягдалыг саванд битүүмжлэн, тэмдэглэгээ байршуулан түр хадгалдаг.
9	Ашиглахгүй болсон химийн хорт болон аюултай бодисын хаягдлыг зөвшөөрөлтэй газраар, эрүүл мэнд, байгаль орчинд аюулгүй аргаар холбогдох комиссыг байлцуулан устгаж, акт үйлдэх	2022 онд	Үйлдвэрийн хэмжээнд	Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах дахин боловсруулах эрх бүхий байгуулалт хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна.

“Цемент Шохой” ТӨХК

10	Даралтат сав, баллоныг аюулгүй хадгалж, ашиглахад тогтмол хяналт тавих	2022 онд	Даралтат сав, баллон бүхий цехүүд	7 хоног бүр цехийн ХАБ-ын инженерүүдтэй хамтран үзлэг шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулж ажилладаг.
11	Уурхайн авто замын аюул бүхий нөхцөл үүссэн хөмсгийг 70/100 см ба техникийн овор хэмжээнээс хамааруулан хийх	2022 онд	Үйлдвэрийн хэмжээнд	Аюул бүхий нөхцөл үүссэн хөмсгийг 70/100 см болгон хийсэн. /Хавсралт №21/
12	Уурхайн технологийн замын зурвасуудын 70/100 см-тэй болгон тэгшилж цацруулагчтай тэмдэг тэмдэглэгээнүүд хийж байршуулах	2022 онд	Үйлдвэрийн хэмжээнд	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийж, Аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлсэн.
13	Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө боловсруулж, баталгаажуулах	2022 онд	Үйлдвэрийн хэмжээнд	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийж, Аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлэн батлуулсан. /Хавсралт №22/
14	Туузан дамжлага ажиллаж байх үед аюулгүйн гэрэл ажиллуулах	2022 онд	Үйлдвэрийн туузан дамжлага	Ажиллаж байх үед аюулгүй гэрэл ажилладаг. /Хавсралт №23/
15	Аюулыг мэдээлэх хуудас ашиглах, тайлагнах	2022 онд	Үйлдвэрийн хэмжээнд	2022 оны 1-3-р саруудад КРІ хэрэгжүүлж тайлан мэдээг тогтмол авсан. /Хавсралт №24/

10. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Цемент шохойн үйлдвэр

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Гүйцэтгэл
1	Ахуйн	Үйлдвэрлэлийн цех, хэсгүүд, оффис зэргээс гарах хог хаягдалд ялгалт хийж, энгийн хог хаягдлыг ангилан түр хадгалах цэгт байрлуулах	01-03-р сарын хугацаанд КРІ хэрэгжүүлж үйлдвэрийн бүх цех хэлтсүүд хог хаягдлыг ангилан ялгах түр хадгалах савтай болсон. Сайхан сумын хот тохижилтын газартай байгуулсан гэрээний дагуу сумын хогийн цэг рүү ачуулдаг.
		Хог хаягдлын цэгийг тусгай хашаа бүхий бетондсон талбайд байрлуулах, тохижуулах, хаягжуулах, 7 хоногт 1 удаа ариутгал хийх, ариутгалын бүртгэл хөтлөх	Хогийн цэгийг бетондсон талбайд байгуулдаг ба 7 хоног бүр ариутгал халдваргүйтгэл хийдэг.
		Нийт ажилчдад 2017 оны 5-р сарын 12-нд батлагдсан "Хог	2022 оны 1-2-р сард халдвар хамгааллын дэглэм сахиж "Нийт ажилчдын сургалт"-

“Цемент Шохой” ТӨХК

		хаягдлын тухай хууль"-ийг танилцуулах сургалт зохион байгуулах, аюултай хог хаягдлыг хадгалах тал дээр түлхүү анхаарах, хяналтыг сайжруулах	ыг зохион байгуулсан. Сургалтын хичээлийн сэдвэнд хог хаягдалын талаар түлхүү орсон.
2	Үйлдвэрийн	Үйлдвэрлэлийн технологиос гарсан хаягдлыг үйлдвэрлэлд нэмэлтээр ашиглах, байгальд хаягдах хог хаягдлыг багасгах	Дутуу шатсан хаягдал козелийг хуурай аргын үйлдвэрт нэмэлтээр ашиглаж байна. Мөн Дулааны станцын үнсийг цементийн нэмэлтээр ашиглаж, байгальд хаягдах хаягдлыг бууруулж ажиллаж байна.
		Үйлдвэрлэлд дахин ашиглах боломжгүй технологийн хаягдал, цэвэрлэгээний тоос, шороог үйлдвэрлэлийн хог хаягдлын отвал руу тээвэрлэх, үйлдвэрийн орчныг цэвэр байлгах, технологийн сахилга батыг нэмэгдүүлэх	Үйлдвэрийн технологиос гарж буй хаягдалд хяналт тавин аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг отвальруу зөөвөрлөдөг.
3	Аюултай	Аюултай хог хаягдлын цэгийг тусгайлан байгуулж, хязгаарлалтын бүс тогтоон уг хаягдлыг битүүмжлэл сайтай саванд хадгалж, таних тэмдэг, анхааруулах санамж байрлуулан, бүртгэл хөтлөн тайлан гаргаж байх.	Цех бүрт аюултай хог хаягдал хадгалах түр цэгийг тусгайлан байгуулан таних тэмдэг, тусгаарлах шугам татсан. /Хавсралт №25/
		Химийн бодисуудыг худалдан авах гэрээ байгуулахдаа нийлүүлэгч компанитай харилцан тохиролцож, химийн бодисуудын сав баглаа, лонхыг тоо ёсоор хүлээлгэн өгөх заалтыг гэрээнд тусгах	Манай компани цөөн тооны химийн бодис авдаг учир худалдагч байгууллага тус заалтыг гэрээнд тусгахаас татгалзсан байна.
		Авто тээврийн хэрэгслүүдийн ашигласан тосыг хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу тогтоож, аюултай хог хаягдал боловсруулах эрх бүхий байгууллагад нийлүүлэх	Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах дахин боловсруулах эрх бүхий байгууллагад хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна.
4	Бүртгэл,гэрээ болон бусад	Үйлдвэрийн орчны хог хаягдлыг цэвэрлэх хуваарийг шинэчлэн баталж мөрдүүлэх	Үйлдвэрийн орчны хог хаягдлыг цех нэгжүүд хариуцсан талбайг тогтоон өгч, цэвэрлэгээг тогтмол хийж гүйцэтгэж байна. /Хавсралт №26/
		Хог хаягдлыг бүртгэлжүүлж, тайлан мэдээг Сэлэнгэ аймгийн МХГ, БОАЖГ, Сайхан болон	Улирал бүр үйлдвэрээс гарсан бүх хаягдлын тоо хэмжээг хөтөлж, нэгтгэн Сэлэнгэ аймгийн БОАЖГ,МХГ, Сайхан болон Орхон сумдын БОХУ байцаагч

“Цемент Шохой” ТӨХК

	Орхон сумын БОХУ байцаагч нарт улирал бүр хүргүүлэх	нарт хүргүүлж ажиллалаа. /Хавсралт №27/
	Цехүүдийн харъяа талбайн цэвэрлэгээний ажлыг тогтмолжуулах, хяналтын системийн хуваарийг боловсруулж, хяналт тавих	Цех нэгжүүд хувиарт талбайн цэвэрлэгээг тогтмол хийж ажилласан. /Хавсралт №26-тэй давхцаж байна/
	Үйлдвэрээс гарах ахуйн хог хаягдлын гэрээг сумын хот тохижилтын газартай, үйлдвэрлэлийн хог хаягдал хуримтлуулах отвалын гэрээг Сайхан сумын ЗДТГ-тай, аюултай хог хаягдлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагатай тус тус байгуулж ажиллах	Тус тус байгуулсан. / Хавсрал № 15-тай давхцаж байна/

11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

№	Үзүүлэлт	Дээж авах цэг	Цэгийн тоо	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Орчны агаар дахь NO ₂ SO ₂	Шохой, Бутлуур, Чулуунцарын Дамжлаг, Тээрэм, Савлах	5*3	18,500	277,500
2	Цацрагийн үзүүлэлт	Бэлэн бүтээгдэхүүн / цемент, шохой/ Үйлдвэрлэлийн хог хаягдлын отвал орчмын хөрс	3*2	5,000	30,000
3	Тоос PM10	Төмөр замын цехийн 3-н давхарт	1*1	20,000	20,000
4	Нийт тоос	Шохой, Бутлуур, Чулуунцарын Дамжлагууд, Тээрэм, Савлах	5*2	15000	150,000
5	Хөрсний үржил шимийн үзүүлэлтүүд/ялзмаг, P Н, давсжилт, хөдөлгөөнд азот-NO ₃ -N, фосфор-P ₂ O ₅ , кали-K ₂ O/, ширхэгийн бүрэлдэхүүн, нягт, эзлэхүүн, жин, ус нэвтрүүлэх чадвар, чийгшил	Дурын 3 байршилд	2*2	56,900	227,600
6	Хөрсний хүнд металлын бохирдол Хар тугалга/Pb/, Хром /Cr/, Цайр/Zn/, Никель	Лаборатори, Засварын нэгдсэн, хогийн отвал орчим	3*2	36,000	216,000

“Цемент Шохой” ТӨХК

	/Ni/, Кадми /Cd/, /ГЗХ, БОХЗТЛ/				
7	Нефтийн бүтээгдэхүүнээр бохирдох хөрсний бохирдол	Хөтөл- 1, 2 орд	2*2	50,000	200,000
8	Ундны усны хиймийн бүрэн шинжилгээ /21 үзүүлэлт/	Усны эх үүсвэрийн худгуудаас дээж авах	2*2	44,000	88,000
9	Бактериологийн бүрэн шинжилгээ /6 үзүүлэлт/	Усны эх үүсвэрийн худгуудаас дээж авах	Хийгдээгүй		
10	Бохир усны химийн бүрэн шинжилгээ /21 үзүүлэлт/	Ахуйн болон үйлдвэрээс гарсан бохир усыг цэвэрлэсний дараа	1*2	25,000	50,000
	Нийт үнэ				1,273,500

АГААРЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

№	Дээж асан цэгийн нэр	Азотын давхар исэл	Хүхэрлэг хий	Тоос (нийт)			PM10		
				Дундаж	Их	Бага	Дундаж	Их	Бага
Хэмжих нэгж мг/м ³									
1	Төмөр замын цехийн 3 давхарт						0.096	0.014	7.55
2	Шохой	0.006	0.005	0.012	0.002	0.109	-	-	-
3	Бутлуур	0.013	0.010	0.007	0.002	0.031	-	-	-
4	Савлах	0.024	0.005	0.012	0.007	0.038	-	-	-
5	Тээрэм	0.019	0.012	0.017	0.004	0.076	-	-	-
6	Чулуунцар	0.064	0.003	0.078	0.011	0.608	-	-	-
MNS4585:2016		0.200	0.450	0.500			0.100		

Шинжилгээний дүнгээс үзэхэд MNS4585:2016 стандартын дагуу байна.
/Шинжилгээний дүн хавсаргав/

УСНЫ ЧАНАР

Стандарт MNS900:2005 (хатуулаг) 7 Стандарт MNS900:2005 (рН) 6.0-9.0			
Шугамын ус	РН	Ерөнхий хатуулаг, мг-экв/дм ³	Он сар өдөр
Сэлэнгэ аймаг, Сайхан сум, Цемент шохойн ТӨХК-ийн, Чулуунцар үйлдвэрийн шугамын ус	8,16	3,51	2022 оны 5 болон 09 сар

Шинжилгээний дүнгээс үзэхэд ундны усны MNS900:2005 стандартын дагуу байна.

ХӨРСНИЙ ЧАНАР

Дээж авсан цэгийн нэр	Тодорхойлсон элементүүд /хэмжих нэгж/ гр/кг		
	РН	Сульфат	Нитрат
Төмөр зам	8.74	130.4	10.7
Орд	8.19	786.2	14.3
Чулуунцар	7.83	1399.4	16.3
MNS 3297:2019	6-9	160.0	130.0

Дээрх цэгүүдээс 0-5 см-н гүнээс авсан хөрсний дээжинд агрохимийн шинжилгээ хийж, MNS 3297:2019 стандарттай харьцуулан хөрсний ариун цэврийн байдлыг ариун цэврийн тоон үзүүлэлтээр үнэлж үзэхэд цэвэр дүгнэгдсэн. /Шинжилгээний дүнг хавсаргав/

12. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

№	Албан шаардлагаар ирүүлсэн зөвлөмж	Зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, 2022 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг зохих байгууллагуудаар батлуулах	Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019.10.29-ны өдрийн А/618 тушаалаар менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. /Хавсралт №28/	100%
2	Техникийн нөхөн сэргээлт хийх, бололцоотой болон хийгдсэн талбайд нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн гүйцэтгэхээр төлөвлөж, санхүүжүүлэх	2022 оны БОМТ-ний дагуу техникийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэсэн.	100%
3	Газар ашиглах гэрээг байгуулах, урьд жилийн төлбөрийг орон нутгийн төсөвт бүрэн төлөврүүлэх	1.Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нийт 175,752,379.24 төгрөг төлсөн.	100%

	2.Газар ашигласны төлбөр нийт 33,173,442.00 төгрөг төлсөн	
	3. Ус ашигласан төлбөр 19,364,397.33 илүү төлөлттэй байна.	
	4. Агаарын бохирдлын төлбөр 359,700 төгрөг төлсөн	100%

13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Гүйцэтгэл
1	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх болон аюулгүй ажиллагааны талаар сургалт зохион байгуулах /сөрөг нөлөөллийг бууруулах хэсэгт дурдсан сэдвүүдийг сургалтын агуулгад багтаах/	2022 онд ковид-19 цар тахал дотоодод гарсантай холбогдуулан нийт ажилтны сургалтыг халдвар хамгааллын дэглэм баримтлуулан 2022 оны 1-2-р сард явуулсан. Байгаль орчны сургалтад агаарын бохирдлын эх үүсвэр, түүнийг бууруулах чиглэлээр ажилтнуудад мэдлэг олгосон. /Хавсралт №5-тай давхцаж байна/
2	Байгаль орчныг хамгаалах асуудлаар хийгдсэн ажлын тайлангаа тогтоосон хугацаанд Сэлэнгэ аймгийн МХГ, БОАЖГ, Сайхан, Орхон сумын БОХУ байцаагчдад тайлагнах	Улирал бүр БОМТөлөвлөгөөний дагуу хийсэн ажлын тайланг холбогдох газруудад хүргэж ажилласан.
3	Ус ашиглах дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл авч, гэрээ байгуулах	Дүгнэлт, гаргуулж, зөвшөөрөл авч, усаар хангагч байгууллагатай гэрээ хийсэн. /Хавсралт № 29/
4	Орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулах	Сайхан сумтай хамтран ажиллах “Нийгмийн хариуцлагийн гэрээ”-г байгуулан гэрээний дагуу ажиллуудыг хийж гүйцэтгэсэн.
5	Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмал хайгуул, ашиглалт явуулах аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны баримт бичгүүдийн хянан бүртгэх хуудсанд гарын үсэг зуруулж, баталгаажуулах	Холбогдох бичиг баримт бэлэн болоогүй байгаа тул түр хойшлогдсон.
6	Гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, галын багаж хэрэгслээр хангах	Галын багаж хэрэгсэл 100% хангагдсан.
7	Ажлын байран дахь анхан шатны тусламжийн хэрэгслийг сэлбэх	Ковид-19 халдварт цар тахлын бэлэн байдал, онцгой дэглэмийн үед ажлын байран дахь анхан шатны тусламжийн хэрэгслийг 100% хангасан.

8	Ашиглаж буй техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал аюулгүй байдлыг хангаж ажиллах	Техник тоног төхөөрөмжид сар бүр эрсдлийн үнэлгээ, 2-р шатны үзлэг хийж, илэрсэн зөрчлийг арилгуулж ажилладаг.
9	Газар, ус ашигласны болон бусад төлбөрийг холбогдох хууль эрхийн актанд заасны дагуу тухай бүр төсвийн дансанд төвлөрүүлэх	Газар, ус, ашигт малтмал ашигласны төлбөрийг холбогдох дансанд төвлөрүүлсэн. /Хавсралт № 30/
10	Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар сурталчилгааны самбар хийж байршуулах	2020 оны 7-н сард ХАБ-ын самбар шинэчлэх шаардлагатай газруудад 25 ширхэг самбар хийж байрлуулсан. Нормын дагуу 2 жилд 1 удаа самбаруудыг шинэчилдэг. Хог хаягдлаа тогтоосон цэгт хаядаг.
11	Байгаль орчныг нөхөн сэргээх баталгаа болгож, 2021 онд байгаль орчныг хамгаалахад төлөвлөсөн зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгийг БОАЖЯамны дансанд төвлөрүүлэх	Байгаль орчныг хамгаалахад төлөвлөсөн зардлын 50%-тай тэмцэх 1,700,000 төгрөгийг тусгай дансанд байрлуулсан./ Хавсралт № 31/

14. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГИЙН ХҮРЭЭНД



➤ Нийгмийн хариуцлагын хүрээнд цех нэгжүүдийн ажилчдынхаа нөөц бололцоонд тулгуурлан Сайхан сумын 1-р багт байрлах сагсан бөмбөг болон хөлбөмбөгийн хуучин талбайг сэргээж засварлаж, шинэ тохижилтын ажлыг хийсэн.

➤ “Тэрбум мод” үндэсний аян

2022 оны 10-р сарын 11-ний өдөр “Ногоон ирээдүйг бүтээцгээе” уриан дор Сайхан сумын иргэдэд 4000 ширхэг нарс, гуйлс, монос, улиас моддын суулгац тараах өдөрлөгийг зохион байгуулсан. Энэхүү өдөрлөгийн зорилго нь хашаатай айл өрхүүдийн ногоон байгууламжыг нэмэгдүүлэх байв.



Дээрх нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажилд нийт 92,824,610 төгрөг зарцуулагдсан.

**15. АЙМАГ, СУМЫН ОРОН НУТГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГЫН ШААРДЛАГААР ХИЙСЭН АЖИЛ БОЛОН НӨЛӨӨЛЛИЙН
БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

БО-ыг хамгаалах үйл ажиллагаа, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид оролцогч талууд	Гүйцэтгэл
Сайхан сумын иргэд	2022 оны 10-р сарын 11-нд “Ногоон ирээдүйг бүтээцгээе” уриан дор мод тараах өдөрлөгө зохиож, мөн Байгаль орчны чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайланг танилцуулсан.
Номгон 3-р багийн иргэд	2022 оны 10-р сарын 11-нд “Ногоон ирээдүйг бүтээцгээе” уриан дор мод тараах өдөрлөгө зохиож, мөн Байгаль орчны чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайланг танилцуулан иргэдтэй ярилцаж санал хүсэлтийг авсан. /Хавсралт №32/

**2022 ОНД БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХЭД ЗАРЦУУЛСАН
ЗАРДАЛ**

№	Төлөвлөгөө, бүрэлдэхүүн хэсгүүд	Зардал, төг
1	Тухайн оны уулын ажлын гүйцэтгэлийн товч танилцуулга	-
2	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	12,028,300
3	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	21,563,000
4	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	158,555,606
5	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	-
6	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	-
7	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,050,000
8	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	1,440,000
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	1,716,000
10	Аймаг, нийслэлийн Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ	272,115,227

11	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	1,700,000
12	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	400,000
НИЙТ		471,568,133

ДҮГНЭЛТ

“Цемент Шохой” ТӨХКомпани нь 2022 онд байгаль орчныг хамгаалах чиглэлээр төлөвлөсөн ажлуудаа “БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ”, “АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ” болон “ЦЕМЕНТ ШОХОЙ” ТӨХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР”-ийн дагуу 76 төрлийн ажлыг гүйцэтгэхдээ 471,568,133 төгрөг зарцуулсан.

1. Уулын ажлын гүйцэтгэл

Уулын ажил	Хэмжих нэгж	НИЙТ		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт /хувь/
Өрөмдлөг	уртааш метр	56280	45986	82%
Хөрс хуулалт	м3	1156413	703137	61%
Шохойн чулуу олборлолт	тонн	609,133	444,092	73%

2. Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний гүйцэтгэл:

- Үйлдвэрийн бүсийн агаарын чанарт 9 ажил төлөвлөж, гүйцэтгэсэн.
- Гадаргын болон газрын доорх усны чанарт 5 ажил төлөвлөж, гүйцэтгэсэн.
- Хөрсөн бүрхэвчид 8 ажил төлөвлөж, гүйцэтгэсэн.
- Газрын хэвлийд 1 ажил төлөвлөж, 100%-тай гүйцэтгэсэн.

3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний гүйцэтгэл:

- 2 ажил төлөвлөж 100%-ийн гүйцэтгэлтэй.

4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэл:

- 1 ажил төлөвлөж 100%-ийн гүйцэтгэлтэй.

5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох асуудал үүсээгүй.

6. Түүх соёлын дурсгалт өв шинээр олдоогүй.

7. Осол, эрсдэл, химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл:

- 16 ажил төлөвлөж хийж 100%-тай гүйцэтгэсэн.

8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл:

- 12 ажил төлөвлөж 100%-ийн гүйцэтгэсэн.

9. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд Сэлэнгэ аймгийн УЦУОШГазартай байгуулсан гэрээний дагуу Агаар,ус, хөрсний шинжилгээг тус тус 3 удаагийн давтамжтай хийлгэсэн. Гүйцэтгэл-100%.

“Цемент Шохой” ТӨХК

10.2022 онд Аймаг нийслэлийн Засаг Даргын тамгын газраас компанид шаардлага ирээгүй байна. Иймд Сэлэнгэ аймгийн МХГ-ын зөвлөмжийн дагуу хийсэн ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан. Гүйцэтгэл-100%

11. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл:

- 11 ажил төлөвлөж 100%-тай гүйцэтгэсэн
- Байгаль орчны хуулийн дагуу Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа болон Байгаль орчны аудитын ажлуудыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүллээ.
- 2022 оны 10 сарын 27-ны байдлаар улсын төсөвт ус, газар, Ашигт малтмал ашигласны 272,115,227 төгрөгний татвар, төлбөрийг төлөөд байна.
- 2022 онд Байгаль орчныг хамгаалах зардалд нийт 471,568,133 төгрөг зарцуулж ажилласан.

2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг БОНБНУ-д тусгагдсаны дагуу амжилттай хэрэгжүүлэн ажиллаа.